Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 90.9 сая, эцсийн үлдэгдэл 164.7 сая төгрөг болж, 73.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	90.84	164.71	73.87	100%
Арилжааны банкин дахь харилцах	0.10	0.00	-0.10	0%
Дүн	90.94	164.71	73.77	100%

Үүнээс байгууллагын төрлөөр

Төсөвт байгууллага	36.15	112.91	76.76	68.6%
Төсөл/сан			0.00	0.0%
Төрийн сан	54.69	51.80	-2.89	31.4%
ТӨҮГ болон ОНӨҮГ	0.10		-0.10	0.0%
Дүн	90.9	164.7	73.8	100%

Эх сурвалж: Сэлэнгэ сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа БХС-ын 54.9 сая, СХС-ын 58.0 сая, ОНӨО 51.8 сая нийт 164.7 сая төгрөг буюу төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байна.

Замд яваа мөнгөн хөрөнгө, хадгаламж дансанд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд үлдэгдэлгүй байна

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 260.7 сая, эцсийн үлдэгдэл 245.6 сая төгрөг болж, 15.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
----------	----------------	-----------------	------------------------	-----------------

Сэлэнгэ сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Ажиллагчидтай холбогдсон авлага	2.88	0.3	-2.58	0%
Зээлийн хүүгийн авлага	25.99	23.75	-2.24	10%
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.44	0.002	-0.438	0%
Байгууллагаас авах авлага	13.83	28.83	15	12%
Хувь хүнээс авах авлага	217.52	192.76	-24.76	78%
Дүн	260.66	245.64	-15.02	100%
Үүнээс байгууллагын төрлөөр				
Сум хөгжүүлэх сан	247.89	220.89	-26.99	89.9%
Хүн эмнэлэг	0.00	0.28	0.27	0.1 %
Цэцэрлэг	2.88	15.00	12.12	6.1%
Орон нутгийн ерөнхий орлого	9.45	9.45	0	3.8%
Ингэт дөл	0.44	0.00	-0.43	0.0%
Дүн	260.66	245.62	-15.04	100%

Эх сурвалж: Сэлэнгэ сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдлийн 59.7 сая төгрөгийн авлага тайланд онд үүссэн бол олон жилийн насжилттай 185.9 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- СХС-гаас олгож буй зээл үлдэгдэл 220.9 сая төгрөгийн 185.9 сая төгрөгийн зээл нь 2011-2019 онд олгосон зээл, үлдсэн 34.8 сая төгрөгийн зээл тодорхойгүй олон жил болсон БХС, Цэнгэл сангийн 2011-2013 оны насжилт ихтэй авлага байна.

Аудитын илрүүлэлт:

- Хүүхдийн тоглоом худалдах, худалдан авахдаа гэрээний 1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй бараа бүтээгдэхүүнээ хугацаандаа аваагүйгээс, төсвийн шууд захирагч төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй авлага үүсгэж, харилцагч байгууллагатай тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна. Тухайлбал: Сургуулийн өмнөх боловсрол 15.0 сая төгрөг.
- БХС, Цэнгэл сангийн 2011-2013 оны насжилт ихтэй 34.8 сая төгрөгийн тооцоо нийлсэн актагүй, эзэн холбогдогч нь тодорхойгүй, сумын ИТХ-аар төсөөт тусгаагдаагүй орхигдсон авлага байна.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэлгүй байна

3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлгүй байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 409.7 сая, эцсийн үлдэгдэл 286.3 сая төгрөг болж, 123.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эдлэх хувь
Тусгай зориулалттай материал	0	3.93	3.93	1.37%
Эм боох материал	21.5	8.35	-13.15	2.92%
Бэлэн бүтээгдэхүүн	6.53	0.00	-6.53	0.00%
Бичиг хэргийн материал			0.00	0.00%
Аж ахуйн материал	48.61	52.38	3.77	18.30%

Сэлэнгэ сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Сэлбэг хэрэгсэл	0	0.00	0.00	0.00%
Түлш шатах тослох материал	2.44	2.76	0.32	0.96%
Барилгын засварын материал	0		0.00	0.00%
Хүнсний материал	24.9	25.45	0.55	8.89%
Бусад хангамжийн материал	290.93	179.99	-110.94	62.87%
Мал амьтад	14.78	13.44	-1.34	4.69%
Дүн	409.69	286.30	-123.39	99%
Үүнээс байгууллагын төрлөөр				
Засаг даргын тамгын газар	159.54	58.24	-101.30	20.34%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.95	1.15	0.20	0.40%
Соёлын төв	15.70	16.07	0.37	5.61%
Сургууль	106.95	83.50	-23.45	29.17%
Хүн эмнэлэг	21.66	32.36	10.70	11.30%
Цэцэрлэг	84.45	94.97	10.52	33.17%
Эмийн эргэлтийн сан	13.91	0.00	-13.91	0.00%
Ингэт дөл	6.53	0.00	-6.53	0.00%
Дүн	409.68	286.30	-123.38	100%

Эх сурвалж: Сэлэнгэ сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 123.4 сая төгрөгөөр буурсан нь ЗДТГ-ын бараа материал дахь бусад хангамж дансанд бүртгэлтэй хашаа, чацарганын мод зэргийн Шинэ хөдөө төсөлд шилжүүлсэн, ЕБС 23.2 сая, СӨБ 17.4 сая, хүн эмнэлэг 1.1 сая төгрөгийн бараа материал акталсан, Эмийн эргэлтийн сан хувьд шилжсэнтэй холбоотой байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 388.8 сая, шилжүүлэн авсан 14.3 сая, бусад эх үүсвэрээр 16.2 сая төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 382.8 сая, шилжүүлсэн 101.9 сая, бүтцийн өөрчлөлтөөр 13.9 сая, дахин үнэлсэн болон акталсан 44.0 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж, 286.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- ↓ Бараа материалын ангиллыг буруу хөрөнгийн шинж чанартай зүйлийг бүртгэсэн УСНББОУС-12 ын дагуу зөв ангилж бүртгээгүй байна. Тухайлбал: СӨБ 6.9, ЭМТ 12.4 сая төгрөг
- ↓ Жилийн эцсийн тооллогоорх бараа материалын үлдэгдэл санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн дүнг зөрүүтэй, тооллогын анхан шатны баримтын хөтлөлт дутуу. Тухайлбал: ЭМТ 32.4 сая төгрөг

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3127.7 сая, эцсийн үлдэгдэл 4223.0 сая төгрөг болж, 1095.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Барилга байгууламж, орон сууц	2,365.81	3,201.17	835.36	76%
Хуримтлагдсан элэгдэл	-101.40	-190.37	-88.97	-5%
Авто-тээврийн хэрэгсэл	611.49	737.49	126.00	17%
Хуримтлагдсан элэгдэл	-368.00	-376.02	-8.03	-9%
Машин тоног төхөөрөмж/компьютер/	807.56	803.94	-3.62	19%
Хуримтлагдсан элэгдэл	-586.20	-443.59	142.61	-11%
Тавилга, аж ахуйн эд хогшил	181.31	178.09	-3.22	4%
Хуримтлагдсан элэгдэл	-97.64	-75.32	22.33	-2%
Зам, гүүрний байгууламж	0.00	0.00	0.00	0%

Сэлэнгэ сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хуримтлагдсан элэгдэл	0.00	0	0.00	0%
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай т.төхөөрөмж	0.00	0	0.00	0%
Хуримтлагдсан элэгдэл	0.00	0	0.00	0%
Түүх соёл, музейн дурсгалт зүйл	0.00	0	0.00	0%
Бусад үндсэн хөрөнгө	405.59	477.11	71.51	11%
Хуримтлагдсан элэгдэл	-232.86	-229.57	3.29	-5%
Дуусаагүй барилга, байгууламж		0	0.00	0%
Ном	33.91	15.51	-18.40	0%
Программ хангамж	1.74	4.44	2.70	0%
Хуримтлагдсан элэгдэл	-1.74	-1.74	0.00	0%
Бусад биет бус хөрөнгө	108.12	121.90	13.78	3%
Хуримтлагдсан элэгдэл			0.00	0%
Дүн	3,127.69	4,223.03	1,095.35	100%
Засаг даргын тамгын газар	706.08	990.10	284.02	23.4%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	3.37	6.69	3.32	0.2%
Соёлын төв	175.43	163.26	-12.17	3.9%
Сургууль	1,484.93	1,446.54	-38.39	34.3%
Хүн эмнэлэг	424.76	446.44	21.67	10.6%
Цэцэрлэг	176.86	1,036.48	859.62	24.5%
Эмийн эргэлтийн сан	3.66	0.00	-3.66	0.0%
Ингэт дөл	152.59	133.52	-19.07	3.2%
Дүн	3,127.69	4,223.03	1,095.35	100%

Эх сурвалж: Сэлэнгэ сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 306.9 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 923.5 сая, дахин үнэлсэн болон бусад 86.1 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас баланст шилжүүлсэн 3.7 сая, акталсан 229.2 сая, дахин үнэлсэн 60.7 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

↓ ЭМТ нь Эрүүл мэндийн газраас шилжүүлсэн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй нь НББ-ийн тухай хуулийн 14.4.2, 14.4.5 дахь заалт, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй 0.9 сая төгрөг

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 141.9 сая, эцсийн үлдэгдэл 857.0 сая төгрөг болж, 715.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР				
Ажилчидтай холбогдсон өглөг	5.95		-5.95	0.0%
Байгууллагад төлөх өглөг	18.62		-18.62	0.0%
Татварын өглөг /ТӨҮГ/	0.04	0.29	0.25	100.0%
Дансны өглөг	0.77		-0.77	0.0%
Дүн	25.38	0.29	-25.09	100.0%
Соёлын төв	0.48	0.00	-0.48	0.0%
Сургууль	1.60	0.00	-1.60	0.0%
Эмийн эргэлтийн сан	18.15	0.00	-18.15	0.0%
Ингэт дөл	5.16	0.29	-4.87	100.0%

Сэлэнгэ сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дүн	25.38	0.29	-25.10	100%
------------	--------------	-------------	---------------	-------------

сурвалж: Сэлэнгэ сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл "Ингэт дөл" ОНӨҮГ-ийн 0.29 сая төгрөгийн татварын өглөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3863.6 сая, эцсийн үлдэгдэл 4919.4 сая төгрөг болж, 1055.8 сая төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ № 6. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,586.83	1,595.64	8.80	32.44%
Өмч /хувийн/ /ГӨҮГ/	190.74	190.74	0.00	3.88%
Хуримтлагдсан үр дүн	-106.18	942.87	1,049.04	19.17%
Өмнөх үеийн үр дүн	-33.41	-98.60	-65.19	-2.00%
Тайлант үеийн үр дүн	-72.77	1,041.47	1,114.24	21.17%
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,192.19	2,190.15	-2.03	44.52%
Дүн	3,863.58	4,919.40	1,055.81	1.00
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан				
Засаг даргын тамгын газар	444.23	458.01	13.78	9.31%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	7.26	7.26	0.00	0.15%
Хүн эмнэлэг	279.65	279.65	0.00	5.68%
Сургууль	666.08	666.08	0.00	13.54%
Цэцэрлэг	136	136	0.00	2.76%
Соёлын төв	48.63	48.63	0.00	0.99%
Эмийн эргэлтийн сан	4.98		-4.98	0.00%
Өмч /хувийн/ /ГӨҮГ/			0.00	0.00%
Ингэт дөл	190.74	190.74	0.00	3.88%
Хуримтлагдсан үр дүн			0.00	0.00%
Орон нутгийн ерөнхий орлого	64.14	61.25	-2.89	1.25%
Орон нутгийн хөгжлийн сан	2.1		-2.10	0.00%
Сум хөгжүүлэх сан	275.39	278.86	3.47	5.67%
Байгаль хамгаалах сан	6.55	54.94	48.39	1.12%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	-3.2	0.34	3.54	0.01%
Эмийн эргэлтийн сан	-7.57		7.57	0.00%
Ингэт дөл	-36.27	-57.51	-21.24	-1.17%
Сургууль	-381.25	-441.48	-60.23	-8.97%
Засаг даргын тамгын газар	15.82	184.76	168.94	3.76%
Соёлын төв	-4.56	-15.87	-11.31	-0.32%
Цэцэрлэг	29.99	912.25	882.26	18.54%
Хүн эмнэлэг	-67.33	-34.67	32.66	-0.70%
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү			0.00	0.00%
Сургууль	1305.44	1305.44	0.00	26.54%
Засаг даргын тамгын газар	405.57	405.57	0.00	8.24%
Эмийн эргэлтийн сан	2.03		-2.03	0.00%
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.26	0.26	0.00	0.01%
Соёлын төв	146.59	146.59	0.00	2.98%
Цэцэрлэг	98.2	98.2	0.00	2.00%

Хүн эмнэлэг	234.1	234.1	0.00	4.76%
ДҮН	3,863.57	4,919.40	1,055.83	1.00

Эх сурвалж: Сэлэнгэ сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5440.29 сая төгрөг болж 1852.15 сая төгрөгөөр өссөн нь СӨБ-ын байгууллагын УТХО-аар баригдсан 835.4 сая төгрөгийн барилга ашиглалтад орсон, ЗДТГ-т ОНХС, БХС зэргээс шилжин ирсэн 85.9 сая, хүн эмнэлэгт 2.3 сая, нийт 923.5 сая төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгө шилжин ирснээс шалтгаалжээ. Үүнд:

- Тайлант хугацаанд аймгийн ИТХ-ын 2020 оны 57 дугаар тогтоолоор "Эмийн эргэлтийн сан"-г хасагдуулах шийдвэр гарсан нь ЗГ-ын оруулсан хувь 4.9 сая буюу хуримтлагдсан үр дүнг -7.6 сая, хөрөнгийн дахин үнэлгээ дүнг 2.0 сая төгрөгөөр бууруулан бүртгэсэн байна.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэлгүй байна.

Хуримтлагдсан үр дүн 1041.5 сая төгрөг болж 1049.0 сая төгрөгөөр өссөн нь тус сумын СӨБ-ийн барилга ашиглалтад орсноос шалтгаалжээ.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансанд эмийн эргэлтийн санг хасагдуулснаас 7.6 сая төгрөгийн залруулга хийсэн байна.

3.5.10 Орлогын данс

Орлогын төлөвлөгөөг 413.9 сая төгрөгөөр баталж, 462.6 сая төгрөгийг бүрдүүлэн, 48.7 сая төгрөгөөр буюу 11.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №7 Орлогын гүйцэтгэл

/сая төгрөг/

ЭЗА	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Хувь
1	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	413.85	462.59	48.74	111.8%
11	ТАТВАРЫН ОРЛОГО	346.55	398.18	51.63	114.9%
110	Орлогын албан татвар	57.98	138.25	80.27	238.4%
1100	Хувь хүний орлогын албан татвар	28.99	69.13	40.14	238.4%
110002	Үйл ажиллагааны орлого	4.00	14.92	10.92	372.9%
110003	Хөрөнгийн орлого	11.49	18.51	7.02	161.1%
110008	Шууд бус орлого	13.50	35.70	22.20	264.5%
113	Хөрөнгийн албан татвар	1.92	2.80	0.88	145.7%
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	0.00	0.07	0.07	
113002	Бууны албан татвар	1.92	2.73	0.81	142.1%
118	Бусад татвар, төлбөр, хураамж	315.64	326.25	10.61	103.4%
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	244.00	254.20	10.20	104.2%
118001	Улсын тэмдэгтийн хураамж	3.00	4.86	1.86	162.0%
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.00	0.36	0.36	
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4.00	5.54	1.54	138.6%
118010	Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	237.00	243.43	6.43	102.7%
1181	Газрын төлбөр	0.00	5.97	5.97	
118101	Газрын төлбөр	0.00	5.97	5.97	
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	71.64	66.09	-5.55	92.3%
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	60.00	64.17	4.17	107.0%

Сэлэнгэ сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1.64	0.90	-0.75	54.6%
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	10.00	1.02	-8.98	10.2%
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	67.30	64.41	-2.89	95.7%
120	Нийтлэг татварын бус орлого	67.30	64.10	-2.89	95.7%
120002	Хүүгийн орлого	67.00	64.10	-2.90	95.7%
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.30	0.31	0.01	103.3%

Татварын орлого 51.6 сая буюу 14.9 хувиар давж, татварын бус орлого 2.9 сая буюу 4.3 хувиар тасарсан байна.

Аудитын илрүүлэлт:

Тайлант хугацаанд төлөвлөгдөөгүй газрын 5.9 сая, ИҮХЭБАТ 1.8 сая, татварын бус болон иргэний газрын эрх борлуулсны 0.5 сая төгрөгийн орлого төвлөрсөн, төлөвлөгдсөн орлогын 9 нэр төрлийн орлого давсан нь ноосны урамшуулал, "Эрдэнэс таван толгой" ХК-ийн хувьцаанаас, хадгаламж нэмэгдсэн, бүртгэлгүй галт зэвсгийг гэрчилгээжүүлж татварт хамруулсан, тусгай зөвшөөрөл эзэмшдэг ААН, байгууллагын хугацааг сунгаснаас, гоожингийн төлбөрийг тухай бүр хамруулсан, хогны орлогыг цахилгааны төлбөртэй хамт авдаг болсон, хөдөөгийн айл өрхийг хогны татварт хамруулсан, Эзд-Хантай-Бүтээлийн нуруу ДЦГ-ын жимсний зөвшөөрлийн хураамж авсан болон ойн самрын ургац сайн байснаас ААН, байгууллагатай гэрээ хийн татвар ногдуулсан зэргээс хамаарч орлого давсан байна. Хэдийгээр орлого нийт дүнгээр давсан ч нэр төрлөөр авч үзвэл ангийн орлого 0.7 сая буюу 45.4 хувь, ус рашааны төлбөр 8.9 сая буюу 89.8 хувь, татварын бус хүү торгууль 2.9 сая буюу 4.3 хувиар тус тус тасарсан байна. Энэ нь 3 байгаль хамгаалагч ан амьтан барих эрхийн зөвшөөрлийн хуудас олгоогүй хариуцлагагүй хандсан, суманд төвлөрөх орлогыг Сэлэнгэ голын сав газрын захиргаа аймагт төвлөрүүлэх шийдвэр гаргасан, ковид-19 цар тахал гарсантай холбоотой иргэдийн хөдөлгөөн харьцангуй багассанаас цагдаагийн хүү, торгуулийн орлого тасарсан байна.

3.5.11 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 213.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас НӨАТ-ын баримтгүйгээр худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг зөрчсөн байна. Тухайлбал: ЭМТ 3.5, ЗДТГ 0.9 БХС 7.2 сая төгрөг.
- Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг зөрчин зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг зөрчин батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна. Тухайлбал: ИТХ 0.1, МСТ 0.5, СӨБ 1.1 сая төгрөг
- Цалингийн зардлаас өглөгийн дансаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэсэн нь НББ-ийн холбогдох стандарт, хууль тогтоомжийг мөрдөөгүй байна. Тухайлбал: Цэцэрлэг 104.7, ИТХ, ЭМТ 55.8, ЗДТГ 2.5 сая төгрөг
- Тендерт шалгараагүй аж ахуй нэгж байгууллагаас эм, эмийн хэрэгслийн худалдан авалт хийсэн байна. Тухайлбал: ЭМТ 11.7

↓ Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5.5 дахь заалт, сангийн сайдын 2015 оны 01 дүгээр 20-ны өдрийн 7-р тушаалыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал: ЭМТ 2.0 сая төгрөг

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Сэлэнгэ сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 02 дугаар тогтоолд зааснаар сумын ЗДТГ тайлант онд 0.3 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 0.31 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 104 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

Орлогын төрөл	/сая төгрөг/			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ЗДТГ	0.30	0.31	0.01	104
ДҮН	0.30	0.31	0.01	104
ЗДТГ-ын байранд үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудын, халаалт, цэвэр бохир усны төлбөр, түрээс	0.30	0.31	0.01	104
ДҮН	0.30	0.31	0.01	104

Төсвийн төлөвлөлт

Тус сумын 2020 оны төсвийг ИТХ-ын 2019 оны VIII/04 дүгээр тогтоолоор орлогыг 3047.2 сая төгрөгөөр баталж ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 24-ний 09/01 тоот тогтоолоор 3364.9 буюу 317.7 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна. Тодотголоор ашигт малтмалаас бусад баялаг ашигласны төлбөрийг 236.0, орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү торгуулийг 60.5, тусгай зориулалтын шилжүүлгийг 52.1 сая төгрөгөөр тус тус нэмж, санхүүгийн дэмжлэгийг 12.6, орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийг 13.2, орон нутгийн байгууллагын санхүүжилтийг 1.6 сая төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 3493.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 3184.1 сая төгрөгийг урсгал зардалд, 184.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 125.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын тусгай зориулалтын шилжүүлгээс 2165.5 сая төгрөг, 1032.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 86.5 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 37.9 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 124.6 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл

ажиллагааны орлогоос, урьд оны үлдэгдлээс 46.1 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 2038.1 сая төгрөг, 1038.1 сая төгрөг орон нутгийн төсвөөс, 76.8 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 34.1 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 136.5 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, урьд оны үлдэгдэл 36.1 сая нийт 3323.6 сая төгрөгийн санхүүжилт буюу 169.6 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 136.5 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 11.9 сая төгрөгөөр давсан нь БХС-гийн орлого 123.1 хувиар давж тайлант жилд ойн самар их хэмжээгээр ургаж ААН, байгууллгатай гэрээ хийн ойн нөөц ашигласны төлбөр хураамж нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3246.9 сая төгрөг буюу 92.9 хувьтай байгаа нь өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажилласан, урсгал үйл ажиллагааны зардалд тэвчиж болох зардлыг санхүүжүүлээгүйгээс шалтгаалсан байна. Үүнд:

- ✚ ЕБС, цэцэрлэгүүдийн халаалтын зардлыг 0.5 сар дутуу халаасан,
- ✚ Урсгал үйл ажиллагааны зардалд тэвчиж болох зардлыг хойшлуулсан,
- ✚ Боловсролын байгууллагын хоол хүнс, үдийн цай, дотуур байрны зардал хэмнэгдсэн,

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 2.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 7 төсөл, арга хэмжээнд 86.5 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 76.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 43.8 сая, дээд шатны төсвийн захирагчаас 18.3 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 276.2 сая, нийт 338.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 0.9, хангамж бараа материалд 4.1, нормативд зардалд 13.7, Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд 13.7, Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 13.8, Бараа үйлчилгээний бусад зардалд 274.5, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 1.2, биет ба биет бус хөрөнгө худалдан авахад 28.0 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 78 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 68 мэдээллийг хугацаа хоцроож, мэдээлээгүй 3, 216.8 сая төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна. Тухайлбал: ОНХС-ын төлөвлөгөө, гүйцэтгэлийг 1 сард мэдээлээгүй, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт, хэтрэл хэмнэлтийн шалтгаан тайлбар, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт,

төсвийн төсөл, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн 161.8 сая төгрөгийн 8 арга хэмжээ, СХС-гийн 55.0 сая төгрөгийн зээл, БХС-гийн 22.0 сая төгрөгийн захирамжийг мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	3	-	3	-	-	-	100
Нийт	3	-	3	-	-	-	100

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 2 тусгай сан нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 тусгай сан 4 байгууллага түүвэрт хамрагдсан, БХС, Баг ХС, Цэнгэл сангууд нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгагдсан байна. Тус сангууд нь тусгай сан болон байгууллагын алинд ч хамаардаггүйгээс төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгдсэн тайлангийн аудитад хамрагджээ.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд ЗДТГ, "Ингэт дөл" ОНӨҮГ "Зөрчилгүй", ЭМТ-д "Сөрөг" дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 335.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 6.6 сая төгрөгийн буруу бичилтийн алдааг аудитын явцад залруулж, 238.8 сая төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 372.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг хүргүүлжээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

➤ Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 6.6 сая төгрөгийн элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бус дахин үнэлгээ дансанд тусгасан.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь хугацаа хоцроосон 68, огт мэдээлээгүй 5 мэдээлэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт, хэтрэл хэмнэлтийн шалтгаан тайлбар, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт, төсвийн төсөл, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжсэн 8 арга хэмжээний 161.8 сая, СХС-гийн 55.0 сая төгрөг, БХС-гийн 22.0 сая төгрөгийн захирамжийг байршуулаагүй байна. Мөн харьяа байгууллагууд нэгдсэн системд мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих

мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3.1, 3.2, 4.1-д заасныг зөрчсөн, тохиолдсон байх, хэрэгжилт, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх

Төвлөрүүлсэн захирагчид 337.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 4 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 281.6 сая төгрөгийн алдаа, зөрчил 0.6 сая төгрөгийн 5 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 101.9 сая төгрөгийн 7 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 178.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 23 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төсвийн Ерөнхийлөн захирагч төсвийн жилийн дундуур хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн жилийн төсөвтөө оруулсан өөрчлөлт, хийсэн зохицуулалтынхаа гүйцэтгэлийг нь анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнадаг байх, Харин төсвийн Төвлөрүүлэн захирагч харьяа байгууллагуудынхаа худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилтийг цаг хугацаанд нь дүгнэх асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Балансын данстай холбоотой асуудал.

4.1.1 Илрүүлэлт: Нэгдсэн санхүүгийн тайланд тусгагдсан авлагын үлдэгдлийн 34.8 сая төгрөгийн тооцоо нийлсэн актгүй, эзэн холбогдогч нь тодорхой бус буюу БХС, Цэнгэл сангийн 2011-2013 оны насжилттай авлагыг сумын ИТХ-ын тогтоолд тусгаж батлаагүй орхигдуулсан нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2 дахь заалтыг хэрэгжүүлэн өр, авлага үүсгэхгүй байх шаардлагыг биелүүлээгүй байна.

4.1.2 Эрсдэл: өр, авлагын насжилт нэмэгдэж, эзэнгүй болох.

4.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн өмнөх оны өр, авлагыг барагдуулах, сангаас олгосон зээлийн хугацаа хэтэрсэн зээлдэгчийн асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, авлагыг бүрэн барагдуулж, төсвийг хохиролгүй болгож, зээлийн гэрээний заалтыг нарийвчлан сангийн журамтай уялдуулан шинэчлэх.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрч хэрэгжүүлж ажиллах, албан тоот ирүүлсэн.

4.2 Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд төлөвлөгдөөгүй газрын 5.9 сая, ИҮХЭБАТ 1.8 сая, татварын бус болон иргэний газрын эрх борлуулсны 0.5 сая төгрөгийн орлого төвлөрсөн, төлөвлөгдсөн орлогын 9 нэр төрлийн орлого давсан нь ноосны урамшуулал, "Эрдэнэс таван толгой" ХК-ийн хувьцаанаас, хадгаламж нэмэгдсэн, бүртгэлгүй галт зэвсгийг гэрчилгээжүүлж татварт хамруулсан, тусгай зөвшөөрөл эзэмшдэг ААН, байгууллагын хугацааг сунгаснаас, гоожингийн төлбөрийг тухай бүр хамруулсан, хогны орлогыг цахилгааны төлбөртэй хамт авдаг болсон, хөдөөгийн айл өрхийг хогны татварт хамруулсан, Зэд-Хантай-Бүтээлийн нуруу ДЦГ-ын жимсний зөвшөөрлийн хураамж авсан болон ойн самрын ургац сайн байснаас ААН, байгууллагатай гэрээ хийн татвар ногдуулсан зэргээс хамаарч орлого давсан байна.

Хэдийгээр орлого нийт дүнгээр давсан ч нэр төрлөөр авч үзвэл ангийн орлого 0.7 сая буюу 45.4 хувь, ус рашааны төлбөр 8.9 сая буюу 89.8 хувь, татварын бус хүү торгууль 2.9 сая буюу 4.3 хувиар тус тус тасарсан байна. Энэ нь 3 байгаль хамгаалагч ан амьтан барих эрхийн зөвшөөрлийн хуудас олгоогүй хариуцлагагүй хандсан, суманд төвлөрөх орлогыг аймагт төвлөрүүлэхээр болсон, ковид-19 цар тахал гарсантай холбоотой иргэдийн хөдөлгөөн харьцангуй багассанаас цагдаагийн хүү, торгуулийн орлого тасарсан байна.

4.2.2 Эрсдэл: Бодиттой төлөвлөөгүйгээс орлого давах тасарснаас гүйцэтгэлд их хэмжээний өөрчлөлт орох, оновчтой бус зарцуулалт хийгдэх

4.2.3 Өгсөн зөвлөмж: Төсөв боловсруулахдаа цаг үе, орчин нөхцөл буюу тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж батлуулах.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4.3 Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

4.3.1 Илрүүлэлт: Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас НӨАТ-ын баримтгүйгээр худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 347 тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь эрх ба үүрэг, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.3.2 Эрсдэл: Орлогыг нуун дарагдуулах, тайлагнахгүй байх

4.3.3 Өгсөн зөвлөмж: НӨАТ тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.3.2, 17.6 заалтуудыг мөрдөж, анхан шатны баримтыг И баримтаар бүрэн баталгаажуулж хэвших.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4.4 Дотоод хяналттай холбоотой асуудал.

4.4.1 Илрүүлэлт: Аудитаар нийт 281.4 сая төгрөгийн 35 алдаа, зөрчил илэрсэн нь үнэлгээ, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.4.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийг зүй зохисгүй, үр ашиггүй зарцуулагдах.

4.4.3 Өгсөн зөвлөмж: Санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах, төсвийн сахилга баттай ажиллах.

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэн ажиллах, албан тоот ирүүлсэн.

4.5 Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

4.5.1 Илрүүлэлт: Сумын 2020 оны төсвийг батлахдаа “төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үд дүн”-г батлаагүй нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4-д “Төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах”, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1.3-т “хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх”, 7.5.6-д “аймаг, нийслэлийн Засаг дарга хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсвийн захирагч бүрээр гаргаж төсвийн төслийн хавсралт байдлаар

боловсруулж, дараах зүйлийг тусгана” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.5.2 Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, зарцуулалт оновчтой бус байх

4.5.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 22.6.4, Сангийн сайдын 7.1.3, 7.5.6-д заасны дагуу “төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үд дүн”-г тодорхойлж батлуулан, хэрэгжилтийг тооцдог байх.


4.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР


Д.АНХБАЯР

Ж.ЭНХЦООДОЛ

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



А.СУВДАА

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.03.25	Аудитын нэр:	Сэлэнгэ сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: БУА-2021/8/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Булган аймгийн Сэлэнгэ сумын Засаг дарга		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч нь хугацаа хоцроосон 68, огт мэдээлээгүй 3 мэдээлэл, хэтрэл хэмнэлтийн шалтгаан тайлбар, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт, төсвийн төсөл, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 8 арга хэмжээний 161.8 сая, СХС-ийн 55.0 сая төгрөг, БХС-ийн 22.0 сая төгрөгийн захирамжийг байршуулаагүй байна. Мөн харьяа байгууллагууд нэгдсэн системд мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	238.8	Алдаа дутагдлыг давтан гаргахгүй, таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.	Засаг дарга, Санхүү албаны дарга	Б.Ууганбаяр, Т.Лхагвасүрэн
2	Нэгдсэн санхүүгийн тайланд тусгагдсан авлагын үлдэгдлийн 34.8 сая төгрөгийн тооцоо нийлсэн актгүй, эзэн холбогдогч нь тодорхой бус буюу БХС, Цэнгэл сангийн 2011-2013 оны насжилттай авлагыг сумын ИТХ-ын тогтоолд тусгаж батлаагүй орхигдуулсан	34.8	Эзэн холбогдогчдыг тогтоож, тооцоо нийлж баталгаажуулах албан шаардлага хүргүүлэх	Засаг дарга, Санхүү албаны дарга	Б.Ууганбаяр, Т.Лхагвасүрэн
3	Орлогын төлөвлөгөөг 413.9 сая төгрөгөөр баталж, 462.6 сая төгрөгийг бүрдүүлэн, 48.7 сая төгрөгөөр буюу 11.8 хувиар давуулан биелүүлсэн байна.	48.7	Төсвийн орлогыг бодитой төлөвлөх, орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд дайчлан ажиллах зөвлөмж өглөө.	Засаг дарга, Санхүү албаны дарга	Б.Ууганбаяр, Т.Лхагвасүрэн
4	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас НӨАТ-ын баримтгүйгээр худалдан авалт хийсэн.	7.1	НӨАТ хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.3.2, 17.6 заалтуудыг мөрдөж, анхан шатны баримтыг И баримтаар бүрэн баталгаажуулж хэвших зөвлөмж өглөө.	Засаг дарга, Санхүү албаны дарга	Б.Ууганбаяр, Т.Лхагвасүрэн
5	Аудитаар нийт 281.4 сая төгрөгийн 35 алдаа, зөрчил илэрсэн нь үнэлгээ, үнэн зөв	281.4	Санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах,	Засаг дарга, Санхүү албаны дарга	Б.Ууганбаяр, Т.Лхагвасүрэн

Сэлэнгэ сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	байх батламж мэдэгдлийг хангахгүй байна		төсвийн сахилга баттай ажиллах зөвлөмж өглөө.		
6	Сумын 2020 оны төсвийг батлахдаа "төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үд дүн"-г батлаагүй нь Төсвийн тухай хуулийн 22.6.4, Сангийн сайдын 7.1.3, 7.5.6-д заасныг зөрчсөн байна.	0	Төсвийн тухай хуулийн 22.6.4, Сангийн сайдын 7.1.3, 7.5.6-д заасны дагуу "төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үд дүн"-г тодорхойлж батлуулан, хэрэгжилтийг тооцдог байх зөвлөмж өглөө.	Засаг дарга, Санхүү албаны дарга	Б.Ууганбаяр, Т.Лхагвасүрэн
	Дүн	610.8			